



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2025/135/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өлгий хот

2025 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын,
дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigul@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн захирал: М.Нурболат
Утас: 70007275 Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**САГСАЙ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Т.НУРЛАН ТАНАА**

2025. 02. 24 № 174
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Сагсай сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сагсай сумын эрүүл мэндийн төв нь 2024 онд 1,423.2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,238.4 сая төгрөг зарцуулж, 87.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилго, 7 зорилтын хүрээнд нийт 38 арга хэмжээ 85 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	135,681,299.11	239,585,976.16
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	32,196,614.88	18,782,830.80
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	32,196,614.88	18,782,830.80
3121	Төгрөг	32,196,614.88	18,782,830.80
31211	Төрийн сангийн харилцах	32,196,614.88	18,782,830.80
33	АВЛАГА	15,372,439.41	148,314,587.90
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	19,982.41	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	11,448,457.00	148,314,587.90
335	Бусад авлага	3,904,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	3,904,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	88,112,244.82	72,488,557.46
351	Түүхий эд материал	54,958,664.82	41,198,424.06
35130	Эм боох материал	54,958,664.82	41,198,424.06
354	Хангамжийн материал	33,153,580.00	31,290,133.40
35410	Бичиг хэргийн материал	2,845,499.00	2,057,099.00
35420	Аж ахуйн материал	22,170,051.00	25,006,164.40
35460	Хүнсний материал	7,020,030.00	3,108,870.00
35470	Бусад хангамжийн материал	1,118,000.00	1,118,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	896,075,727.99	1,156,106,768.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	896,075,727.99	1,156,106,768.36
392	Биет хөрөнгө	878,609,728.03	1,138,750,768.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	822,265,317.00	1,013,887,517.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(136,744,925.45)	(164,920,400.85)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	123,864,994.00	144,456,656.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(75,138,661.85)	(90,762,632.50)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	179,320,684.85	281,189,484.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,212,392.19)	(53,270,366.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,618,815.00	30,118,815.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,472,103.33)	(22,056,304.44)
39214	Бусад үндсэн хөрөнгө	458,000.00	458,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(350,000.00)	(350,000.00)
393	Биет бус хөрөнгө	17,465,999.96	17,355,999.92
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(110,000.04)	(220,000.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	17,026,000.00	17,026,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,031,757,027.10	1,395,692,744.52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	43,049.00	71,259,518.17
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	43,049.00	71,259,518.17
413	Өглөг	43,049.00	71,259,518.17
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	29,336,443.33
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	21,750.00	-
4136	Бусад өглөг	21,299.00	41,923,074.84
41361	Байгууллагад төлөх өглөг	21,299.00	41,923,074.84
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,031,713,978.10	1,324,433,226.35
51	Засгийн газрын хувь оролцоо	1,031,713,978.10	1,324,433,226.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	590,926,695.50	590,926,695.50
51101	Өмч:- төрийн	590,926,695.50	590,926,695.50
512	Хуримтлагдсан үр дүн	(110,937,808.37)	181,781,439.88
51210	Өмнөх үеийн үр дүн	(110,937,808.37)	(110,937,808.37)
51220	Тайлант үеийн үр дүн	-	292,719,248.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	551,725,090.97	551,725,090.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,031,757,027.10	1,395,692,744.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	961,801,860.64	1,682,548,994.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	69,059,691.00	327,050,531.46
120	Нийтлэг татварын бус орлого	69,059,691.00	327,050,531.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	6,498,449.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	66,368,999.00	303,833,862.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	2,690,692.00	16,718,220.46
120042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	6,498,449.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	892,742,169.64	1,355,498,462.72
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,314,100.00	59,193,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,314,100.00	59,193,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	861,428,069.64	1,296,304,862.72
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	861,428,069.64	1,296,304,862.72
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	957,201,978.14	1,389,829,745.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	957,201,978.14	1,389,829,745.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	955,926,287.14	1,389,740,096.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	606,033,282.68	922,115,899.74
210101	Үндсэн цалин	444,769,979.46	732,452,276.42
210102	Нэмэгдэл	123,677,892.57	150,436,158.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,900,000.00	4,564,000.00
210104	Урамшуулал	31,685,410.65	34,663,465.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,579,663.16	105,892,137.00
210201	Тэтгэврийн даатгал	52,131,434.77	73,300,737.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,133,204.35	8,147,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,906,563.68	4,074,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,218,950.67	4,074,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,189,509.69	16,295,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,836,409.00	57,894,254.00
210301	Гэрэл, цахилгаан	3,386,409.00	3,093,554.00
210302	Түлш, халаалт	20,450,000.00	54,800,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,586,710.00	65,798,560.00
210401	Бичиг хэрэг	4,862,350.00	1,728,500.00
210402	Тээвэр, шатахуун	55,052,960.00	59,892,710.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,606,100.00	1,204,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,065,300.00	2,973,150.00
2105	Нормативт зардал	122,350,208.48	143,831,677.56
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	103,882,228.48	115,846,217.56
210502	Хоол, хүнс	18,467,980.00	19,194,460.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	8,791,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,586,000.00	12,223,196.44
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,572,100.00	8,190,000.00
210604	Урсгал засвар	5,013,900.00	4,033,196.44
2107	Томилолт, зочны зардал	1,085,000.00	2,594,000.00
210702	Дотоод албан томилолт	1,085,000.00	2,594,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,000.00	262,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	108,000.00
210807	Газрын төлбөр	75,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	88,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,794,013.82	79,128,371.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,722,170.00	22,576,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,071,843.82	56,551,621.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,275,691.00	89,649.56
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,275,691.00	89,649.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,275,691.00	89,649.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	4,599,882.50	292,719,248.25
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,599,882.50	292,719,248.25

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	881,293,712.64	1,225,130,780.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	6,498,449.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	6,498,449.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	6,498,449.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	6,498,449.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	881,293,712.64	1,218,632,331.82
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,314,100.00	59,193,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,314,100.00	59,193,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	849,979,612.64	1,159,438,731.82
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	849,979,612.64	1,159,438,731.82
2	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	885,289,483.79	1,229,895,764.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	885,289,483.79	1,229,895,764.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	884,013,792.79	1,229,806,115.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	609,098,889.06	896,804,811.00
210101	Үндсэн цалин	341,663,255.08	707,141,187.65
210102	Нэмэгдэл	198,182,607.70	150,436,158.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,978,000.00	4,564,000.00
210104	Урамшуулал	59,900,801.28	34,663,465.15
210105	Гэрээт ажлын хөлс	1,374,225.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,515,224.19	101,846,800.00
210201	Тэтгэврийн даатгал	50,163,271.97	69,255,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,870,351.98	8,147,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,856,615.38	4,074,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,147,739.09	4,074,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,477,245.77	16,295,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,490,409.00	53,990,254.00
210301	Гэрэл, цахилгаан	3,386,409.00	3,093,554.00
210302	Түлш, халаалт	23,104,000.00	50,896,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58,819,680.00	66,830,310.00
210401	Бичиг хэрэг	3,145,200.00	3,046,850.00
210402	Тээвэр, шатахуун	50,797,380.00	60,074,860.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,606,100.00	1,204,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	324,000.00	279,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,947,000.00	2,225,200.00
2105	Нормативт зардал	84,253,545.54	71,963,843.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	67,736,345.54	58,144,793.90
210502	Хоол, хүнс	15,782,200.00	13,726,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	735,000.00	93,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,397,500.00	13,669,896.44
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,544,600.00	7,730,000.00
210604	Урсгал засвар	6,852,900.00	5,939,896.44
2107	Томилолт, зочны зардал	1,085,000.00	2,804,000.00
210702	Дотоод албан томилолт	1,085,000.00	2,804,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,000.00	312,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	108,000.00
210807	Газрын төлбөр	75,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	138,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,278,545.00	21,584,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,278,545.00	21,584,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,275,691.00	89,649.56
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,275,691.00	89,649.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,275,691.00	89,649.56

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(3,995,771.15)	(4,764,984.08)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,491,500.00	8,648,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,491,500.00	8,648,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,491,500.00	8,648,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,491,500.00	8,648,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(12,491,500.00)	(8,648,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(16,487,271.15)	(13,413,784.08)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	48,683,886.03	32,196,614.88
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	32,196,614.88	18,782,830.80

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(115,537,690.87)	1,027,114,095.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(115,537,690.87)	1,027,114,095.60
Тайлант үеийн үр дүн	-	-	4,599,882.50	4,599,882.50
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(110,937,808.37)	1,031,713,978.10
2024 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(110,937,808.37)	1,031,713,978.10
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(110,937,808.37)	1,031,713,978.10
Тайлант үеийн үр дүн	-	-	292,719,248.25	292,719,248.25
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	181,781,439.88	1,324,433,226.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(32,196,614.88)		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,423,176,100.00	1,238,454,915.34	184,721,184.66	87.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,423,176,100.00	1,238,454,915.34	184,721,184.66	87.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,423,176,100.00	1,238,454,915.34	184,721,184.66	87.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,015,114,800.00	896,727,711.00	118,387,089.00	88.3
210101	Үндсэн цалин	573,696,000.00	352,807,314.78	220,888,685.22	61.5
210102	Нэмэгдэл	316,647,600.00	150,436,158.20	166,211,441.80	47.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,032,000.00	4,564,000.00	5,468,000.00	45.5
210104	Урамшуулал	114,739,200.00	34,663,465.15	80,075,734.85	30.2
210105	Гэрээт ажлын хөлс	-	354,256,772.87	(354,256,772.87)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,889,400.00	101,846,800.00	25,042,600.00	80.3
210201	Тэтгэврийн даатгал	86,284,800.00	69,255,400.00	17,029,400.00	80.3
210202	Тэтгэмжийн даатгал	10,151,100.00	8,147,700.00	2,003,400.00	80.3

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	5,075,600.00	4,074,000.00	1,001,600.00	80.3
210204	Ажилгүйдлийн даатгал	5,075,600.00	4,074,000.00	1,001,600.00	80.3
210205	Эрүүл мэндийн даатгал	20,302,300.00	16,295,700.00	4,006,600.00	80.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,584,600.00	55,497,150.44	87,449.56	99.8
210301	Гэрэл, цахилгаан	4,601,100.00	4,600,450.44	649.56	100.0
210302	Түлш, халаалт	50,983,500.00	50,896,700.00	86,800.00	99.8
2104	Хангамж, бараа материалын зардал	70,445,100.00	66,907,410.00	3,537,690.00	95.0
210401	Бичиг хэрэг	3,291,300.00	3,046,850.00	244,450.00	92.6
210402	Тээвэр, шатахуун	61,544,000.00	60,074,860.00	1,469,140.00	97.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,383,600.00	1,204,200.00	1,179,400.00	50.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	279,200.00	279,200.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,947,000.00	2,302,300.00	644,700.00	78.1
2105	Нормативт зардал	98,640,600.00	71,963,843.90	26,676,756.10	73.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	82,675,300.00	58,144,793.90	24,530,506.10	70.3
210502	Хоол, хүнс	15,413,900.00	13,726,050.00	1,687,850.00	89.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	551,400.00	93,000.00	458,400.00	16.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,632,200.00	12,163,000.00	6,469,200.00	65.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,544,600.00	7,730,000.00	4,814,600.00	61.6
210604	Урсгал засвар	6,087,600.00	4,433,000.00	1,654,600.00	72.8
2107	Томилолт, зочны зардал	5,125,000.00	2,804,000.00	2,321,000.00	54.7
210702	Дотоод албан томилолт	5,125,000.00	2,804,000.00	2,321,000.00	54.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,615,300.00	312,000.00	1,303,300.00	19.3
210803	Даатгалын үйлчилгээ	140,000.00	-	140,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,000.00	66,000.00	74,000.00	47.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	163,400.00	108,000.00	55,400.00	66.1
210807	Газрын төлбөр	75,000.00	-	75,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,096,900.00	138,000.00	958,900.00	12.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,129,100.00	30,233,000.00	896,100.00	97.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,129,100.00	30,233,000.00	896,100.00	97.1
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,423,176,100.00	1,225,041,131.26	198,134,968.74	86.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	59,193,600.00	59,103,950.44	89,649.56	99.8
132001	Орон нутгийн төсвөөс	59,193,600.00	59,103,950.44	89,649.56	99.8
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,363,982,500.00	1,159,438,731.82	204,543,768.18	85.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,363,982,500.00	1,159,438,731.82	204,543,768.18	85.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	6,498,449.00	(6,498,449.00)	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	6,498,449.00	(6,498,449.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	32,196,614.88	(32,196,614.88)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	18,782,830.80	(18,782,830.80)	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31	38	(7)	122.6
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	22	28	(6)	127.3
620003	Үйлчлэх ажилтан	8	9	(1)	112.5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сагсай сумын Эрүүл мэндийн төв нь эмнэлгийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай, үзүүлэх үйлчлүүлэгчийн эрхийг дээдлэхэд оршино гэсэн эрхэм зорилготой байгууллага юм.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, оношилгоо шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх,
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тогтмол хүргэх
- Эхийн эндэгдэл гаргахгүй байх, эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах
- Хүүхдийн эндэгдлийг буруулах
- Халдварт болон халдварт бус өвчнийг буруулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сагсай сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/
- Засгийн газрын 2024.02.28-ний өдрийн Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 84 дүгээр тогтоол,
- Засгийн газрын 2024.03.27-ний өдрийн Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 128 дугаар тогтоол,
- Эрүүл мэндийн үндэсний зөвлөл (ЭМҮЗ)-ийн 2024 оны Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 05 дугаар тогтоол,
- Эрүүл мэндийн үндэсний зөвлөл (ЭМҮЗ)-ийн 2024 оны Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 06 дугаар тогтоол.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд мэргэжлийн байгууллагуудаас ямар нэгэн хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус эрүүл мэндийн төвийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/37 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон ажиллаж байна. Энэхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 363,935.7 мянган төгрөгөөр буюу 35.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	32,196.6	18,782.8	(13,413.8)
Авлага	15,372.4	148,314.6	132,942.2
Бараа материал	88,112.2	72,488.6	(15,623.6)
Үндсэн хөрөнгө	896,075.7	1,156,106.8	260,031.1
Нийт хөрөнгө	1,031,756.9	1,395,692.8	363,935.9
Өр төлбөр	43.0	71,259.5	71,216.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,031,714.0	1,324,433.2	292,719.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,031,757.0	1,395,692.7	363,935.7

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 18,782.8 мянган төгрөг болж 13,413.8 төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 1,218,632.3 мянган төгрөгийн санхүүжилт авч 1,231,956.5 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 148,314.6 мянган төгрөг болж 132,942.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 1,296,304.9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж 1,159,438.7 мянган төгрөгийг санхүүжилт авч, санхүүжилт дутуу авсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 72,488.6 мянган төгрөг болж 15,623.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 16,718.2 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, урсгал санхүүжилтээс 193,410.6 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 201,122.3 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулж 24,630.1 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,156,106.7 мянган төгрөг болж, 260,031.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 303,833.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, нийт 12,748.8 мянган төгрөгийн /төсвийн хөрөнгөөр 8,648.8 мянган төгрөгийн хөрөнгө, дараа

тооцоогоор 4,100.0 мянган төгрөг/ үндсэн хөрөнгө худалдан авч, 56,551.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 71,259.5 мянган төгрөг болж өссөн нь санхүүжилт дутуу авсантай холбоотой.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 1,324,433.2 мянган төгрөг болж 292,719.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлан оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,159,438.6 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 6,498.4 мянга, нийт зарлагыг 1,229,895.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 896,804.8 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 101,846.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 66,830.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 53,990.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 13,669.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 11,145.5 мянган төгрөгөөр бууруулж, нормативт зардлыг 17,437.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 312.1 мянган төгрөг нэмэгдүүлж, 1,229,806.1 мянган төгрөгөөр баталсан. Энэ нь төсвийг бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүйтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг эрүүл мэндийн даатгалын сангаас 1,363,982.5 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 59,193.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төсөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 1,159,438.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 6,498.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 59,104.0 мянган төгрөг, нийт 1,225,041.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд оны эхний үлдэгдлээс 32,196.6 мянган төгрөг, тайлант хугацааны санхүүжилтээс 1,206,258.3 мянган төгрөг, нийт 1,238,454.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Нийт төсвийн гүйцэтгэл 1,238,454.9 мянган төгрөг буюу 87.0 хувьтай байгаа нь Нэг иргэнд ноогдох норматив төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийг 13,010.6 мянган төгрөг, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний төсвийг 171,620.9 мянган төгрөг, Төрийн өмчийн барилгын тогтмол зардлыг 89.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2.Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	Нэг иргэнд ноогдох норматив	1,015,378.5	1,002,367.9	13,010.6	98.7%	
2	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	348,604.0	176,983.1	171,620.9	50.8%	
3	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	59,193.6	59,104.0	89.6	99.8%	
	Дүн	1,423,176.1	1,238,454.9	184,721.2	87.0%	

Хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 87.0 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

2024 оны төсвийн жилд худалдан авалтын төлөвлөгөө гараагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд эм боох материал 94,506.8 мянган төгрөгөөр, аж ахуйн материал 22,016.0 мянган төгрөгөөр, түлш, шатах тослох материал 61,582.7 мянган төгрөгөөр, хүнсний материал 15,305.0 мянган төгрөгөөр тус тус худалдаж авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотойгоор цалингийн нэмэгдэл урамшуулал, үндсэн хөрөнгийн бүртгэл болон баримт баталгаажуулалт, Төрийн хэмнэлтийн хуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Лайт энд Дилайт Аудит” ХХК-ийн аудитор Л.Мөнхцэцэг гүйцэтгэж, аудитын менежер Ц.Төмөрсүх, компанийн захирал М.Нурболат нар анхан шатны чанарын хяналтыг, Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 969,315.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 646.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 31 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 14 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш нийт 86 удаагийн 2,845,710 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ мэдээлэхээс 15 удаагийн 260,057.4 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээллийг нөхөж байршуулан зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,706.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тавьсан ба бүрэн барагдуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	2,706.1	1	2,706.1	100.0
Нийт дүн	1	2,706.1	1	2,706.1	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 3,907.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав.

Залруулга: Цалин хөлс болон нэмэгдэл урамшилын зардал, ажил олгогчоос төлөх шитгэлийн зардлыг хооронд гүйлгэж бүртгэснийг залруулав.

Аудитаар нийт 2 зөрчил² илэрсэнд 2 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Зөвлөмж:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ТБОНӨБАҮХАТ)-ийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.5 "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно", 45 дугаар зүйлийн 45.3. "Энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд төсвийн шууд захирагч захиалагч байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

1.2.Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заглуулсан		Заглуулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цалин хөлс болон нэмэгдэл урамшиллын зардал, ажил олгогчоос төлөх шитгэлийн зардлыг хооронд гүйлгэж бүртгэсэн.	1	3,907.0	-	-	1	3,907.0	1	3,907.0	-	-	-	-
ДҮН	1	3,907.0	-	-	1	3,907.0	1	3,907.0	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс						Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Төлбөрийн акт		Албан шаардлага	Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
		Тоо	Дүн		Тоо	Дүн	Тоо		Дүн
Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, шууд худалдан авалт хийсэн байна.	1	-	-	-	-	1	-	-	
ДҮН	1	-	-	-	-	1	-	-	

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж
			Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш нийт 86 удаагийн 2,845,710 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ мэдээлэхээс 15 удаагийн 260,057.4 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон байна.	1	-	-	-	-	-	1
ДҮН	1	-	-	-	-	-	1

/мянган төгрөгөөр/